МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 18 өдөр Дугаар 183 Улаанбаатар хот

Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 48.3.2 дах заалт, "Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010-2014 онд хөгжүүлэх бодлого"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сувилахуйн албаны даргын ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг нэгдүгээр, арга зүйч сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг хоёрдугаар, ахлах сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг гуравдугаар, өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг дөрөвдүгээр, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг тавдугаар, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг зургаадугаар, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дотрын кабинетийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг долоодугаар, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг наймдугаар, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын кабинетийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг есдүгээр, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн дотрын тасгийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг аравдугаар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн амбулаторийн дотрын кабинетийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг арваннэгдүгээр, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн мэс заслын тасгийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг арванхоёрдугаар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо,

031208

эмчилгээний төвийн амбулаторийн мэс заслын кабинетийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг арвангуравдугаар, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн лаборантын ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг арвандөрөвдүгээр, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, тусгай мэргэжлийн төвийн лаборантын ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг арвантавдугаар, дүрс оношлогооны техникчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг арванзургаадугаар, эм найруулагчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг арвандолоодугаар, сумын эмийн санчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг арваннаймдугаар, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эх баригчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг арванесдүгээр, аймгийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, тусгай мэргэжлийн төвийн эх баригчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг хорьдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү загварын дагуу ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж, мөрдүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Баярт)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2009 оны 442 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Н.ХҮРЭЛБААТАР

Эрүүл мэндийн сайдын 2012 он
.5.. дугаар сарын 18..-ны өдрийн 183..
тоот тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар .....

“А” Нийтлэг үндэслэл

Байгууллагын нэр		Нэгжийн нэр	
Сум дундын эмнэлэг, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, клиник, амаржих газар, сувилал, бусад эмнэлгүүд		**Сувилахуйн алба**	
Ажлын байрны нэр		Ангилал	Зэрэглэл
Сувилахуйн албаны дарга		Засгийн газрын тогтоолд зааснаар	
Шууд харъяалагдах ажлын байр (албан тушаал)		Шууд харъяалах албан тушаал	
Байгууллагын дарга		Тасгийн ахлах сувилагч	
Ажлын байрны зорилго	Сувилахуйн тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдэд чанарын өндөр түвшинд үзүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах		
Ажлын байрны үндсэн зорилт	1. Сувилахуйн албыг ерөнхий удирдлага, зохион байгуулалтаар хангах; 2. Байгууллагын түвшинд сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний нөөцийн хөгжил, сургалт, нийгмийн асуудлыг удирдан зохион байгуулах 3. Байгууллагын түвшинд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээг ерөнхий удирдлагаар хангах, 4. Сувилахуй, эмнэлгийн бусад тусгай мэргэжлээр үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанарыг баталгаажилтийг хангах; 5. Бусад		

“Б” Ажлын байрны гол үйл ажиллагаа

	Хугацаа
<u>Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд</u> - Сувилахуйн албаны үйл ажиллагааний төлөвлөгөө, төлөвлөлтийг боловсруулан, хэрэгжүүлэх Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандарт болон холбогдох зааврыг мөрдүүлж ажиллах - Сувилахуйн албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, - Сувилахуйн албаны гишүүд, тасгуудын ахлах сувилагч нарын ажил үүргийн хуваарийг тодорхойлж, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан, зохих албан тушаалтнаар	- Тогтмол - Тогтмол - Тогтмол

баталгаажуулан, хэрэгжилтийг хангана. - Сувилахуйн албаны арга зүйч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах - Сувилгаа, асаргаатай холбогдсон асуудлаар тасгийн ахлах сувилагч нарт үүрэг даалгавар өгөх, зөвлөх, ажлыг хянах - Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг ажилд авах, хөдөлмөрийн гэрээ цуцлах, цалин нэмэх, хасах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхэд оролцох, санал өгөх - Эмнэлгийн сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг баталгаажуулах, багц цагийн сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах - Сувилагч нарын болон бусад тусгай мэргэжилтний ажлын уялдаа холбоог хангах, ажлын ачааллыг тэнцүүлэх, ажил үүргийн хуваарь, ажил дүгнэх шалгуурыг боловсруулан мөрдүүлэх	- Тогтмол - Тогтмол - Тогтмол - Тогтмол - Тогтмол
<u>Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд</u> - Сувилахуйн тусламж, үйлчилгээний стандарт, сувилагааны удирдамжийг эмнэлгийн түвшинд хэрэгжүүлэх, шинэчлэн боловсруулах - Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг ажлын байран дээр сургах, мэргэшүүлэх, дадлагажуулах ажлыг зохион байгуулах	- Тогтмол - Тогтмол
<u>Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд</u> - Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын хөтөлбөрийг боловсруулан, эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулах, хэрэгжилтийг хангах	- Тогтмол
<u>Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд</u> - Өөрийн мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх - Сувилахуйн тусламж, үйлчилгээний талаар судалгаа хийх, онол практикийн бага хурал зохион байгуулах, сувилагч нарын хийсэн судалгааны үр дүнг үндэслэн тусламж, үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулахад оролцох, хянах, үр дүнг тооцох	- Тогтмол - Тогтмол

В.Тавигдах шаардлага

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1 Эмнэл зүйн ур чадвар	Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	- Бакалаврын боловсролын зэрэгтэй төгссөн	
		Мэргэжил	- Сувилагч - “Сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	Мэргэжлийн зэрэгтэй байх
		Мэргэшил	- Төрөлжсөн мэргэшлийн сувилахуйн сургалтанд	Урт, богино хугацааны

		суралцсан байх	удирдлагын сургалтад суралцсан байх
	Туршлага	- Арга зүйч сувилгачаар 3-аас доошгүй жил ажилласан туршалгатай байх,	Ахлах сувилагчаар ажилласан байх
1.2 Эмнэл зүйн бус ур чадвар	Гадаад хэл	- Англи хэлний зохих мэдлэгтэй	Бусад гадаад хэлний мэдлэгтэй байж болно
	Компьютерийн мэдлэг	- Оффисын хэрэглээний программ дээр ажиллах - Интернэтийн орчин, дотоод сүлжээнд ажиллах	
	Судалгааны арга зүй	- Статистикийн талаар тодорхой мэдлэгтэй байх	
1.3 Бусад ур чадвар	- Удирдан зохион байгуулах - Манлайлах - Шийдвэр гаргах - Багаар ажиллах - Яриа, харилцаа, хувийн соёлтой байх - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх		
1.4.Тусгай шаардлага:	- Төрийн албан хаагчийн болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах - Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх		

Г. Хүчин зүйлс

1. Ажлын байрны харилцах субъект	
Байгууллагын дотор талд: - Тасгийн эрхлэгчтэй ажлын байрны нөхцөлийг сайжруулах, ажлын байрны стандартыг хангуулах, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх, эмчилгээ, сувилахуйнтусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар; - Эмнэлгийн хүний нөөцийн албатай сувилагч нарын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын асуудлаар; - Тасгийн ахлах сувилагчтай мэргэжлийн тусламж, үйлчилгээ, ажлын үүрэг, хариуцлага болон сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, сувилагч нарын нийгмийн	Байгууллагын гадна талд: - Үйлчлүүлэгч, түүний асран хамгаалагч, ар гэрийнхэнтэй үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн асуудлаар; - Үйлчлүүлэгч, түүний ар гэр, асран хамгаалагч, харгалзан дэмжигч - Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмч нар - Бусад төв эмнэлэг, тусгай мэргэжлийн эмнэлэг, бүсийн оношлогоо,

асуудлын талаар шат дараалан харьцах; - Тасгийн эмч нар, бусад сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнтэй үйлчлүүлэгчийн оношлогоо, эмчилгээ, сувилахуйн асуудлаар харьцана.		эмчилгээний төвийн эмч нар - Тухайн мэргэжлийн чиглэлээрх мэргэжлийн нийгэмлэг, холбоод
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага		Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг эмнэлгийн даргын өмнө хариуцна
3. Ажлын байрны нөөц хэрэгсэл	3.1.Санхүүгийн	- Засгийн газрын тогтоолд зааснаар цалинг тогтоох - Хууль тогтоомжоор олгогдох бусад нэмэгдэл ба нэмэгдэл хөлс, урамшуулал
	3.2.Материалын	- Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж - Ажлын байрны стандартыг хангасан өрөө, тавилга - Компьютер, дагалдах хэрэгслийн хамт - Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл - Дотуур холбоо, дотоод сүлжээ
	3.3.Хүний	- Тасгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад ажилтантай хамтран ажиллах
	3.4.Бусад	- Эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт тухай бүр хамрагдах
4. Ажлын байрны нөхцөл		Хэвийн
5. Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр		Шаардлагатай тохиолдолд арга зүйч сувилагч орлон ажиллана.

Д.Баталгаажуулалт

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан		Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
..... (байгуулагын нэр) ..... (дарга/захирлын эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) ..... (Гарын үсэг) оны ...сарын ...-ны өдөр	..... (байгуулагын нэр) ..... (шууд удирдах албан хаагчийн эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) ..... (Гарын үсэг) оны ...сарын ...-ны өдөр	..... (байгуулагын нэр) ..... (мэргэжилтний эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) ..... (Гарын үсэг) оны ...сарын ...-ны өдөр

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
.5.. дугаар сарын 18...-ны өдрийн 183...
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР
Дугаар .....

“А” Нийтлэг үндэслэл

Байгууллагын нэр	Нэгжийн нэр	
Сум дундын эмнэлэг, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, клиник, амаржих газар, сувилал, бусад эмнэлгүүд	Сувилахуйн алба	
Ажлын байрны нэр	Ангилал	Зэрэглэл
Арга зүйч сувилагч	Засгийн газрын тогтоолд зааснаар	
Шууд харъяалагдах ажлын байр/албан тушаал	Шууд харъяалах албан тушаал	
- Эмнэлгийн дарга/захирал - Сувилахуйн албаны дарга	Эмнэлгийн сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, ажилтнууд	
Ажлын байрны зорилго	Байгууллагын сувилахуйн албанд орон тоогоор ажиллах ба сувилахуйн тусламж-үйлчилгээний чанарын хяналт, стандартын хэрэгжилтийг зохион байгуулах	
Ажлын байрны үндсэн зорилт	1. Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлээр үзүүлэх тусламж үйлчилгээний удирдамж, стандартын хэрэгжилтийг хангах, 2. Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлээр үзүүлэх тусламж үйлчилгээнд чанарын хяналт тавих, чанарын удирдамжийн хэрэгжилтийг хангах, 3. Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, тэдний судалгаа шинжилгээний ажлын чадавхийг сайжруулах 4. Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний нийгмийн халамжийн талаарх үйл ажиллагааг зохицуулах, 5. Сургалтанд хамрагдан, мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх, 6. Бусад	

Б. Ажлын байрны гол үйл ажиллага

Ажлын байрны гол үйл ажиллагаа:	**Хугацаа**
Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд: - Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлээр үзүүлэх тусламж үйлчилгээний удирдамж, стандартыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан мөрдөж ажиллах, - Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажлын үр дүнг	- Тогтмол - Тогтмол

үнэлэхэд оролцох, - Тасгуудад сувилагч нарыг тойрон ажиллуулах хуваарь болон сувилагчдын ажлын болон ээлжийн хуваарийг батлан, зохицуулах, хяналт тавих ба үүнтэй холбоотой шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй сувилахуйн албаны дарга болон бусад холбогдох албан тушаалтанд танилцуулж шуурхай арга хэмжээ авч ажилах, - Сувилагааны үйл ажиллагаатай холбоотой стандарт, эмнэл зүйн удирдамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тасаг нэгжийн тусламж, үйлчилгээний онцлогт тохирсон удирдамжийг боловсруулан, хэрэгжүүлэх	- Тогтмол - Тогтмол
Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд: - Ахлах сувилагч нарт тусламж үйлчилгээний талаар арга зүйн зөвлөгөө өгч, чиглүүлэн ажиллах, - Тусламж, үйлчилгээний чанарын стандартыг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэх талаар төлөвлөгөө гарган, тасаг нэгжүүдэд хяналт тавих, хэрэгжилтийг хангах, - Тусламж, үйлчилгээний талаар үйлчлүүлэгчдээс, тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслийн хангалт бэлэн байдлын талаар сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдээс санал болон сэтгэл ханамжийн судалгаа авах, үр дүнг тооцон ажиллах,	- Тогтмол - Тогтмол - Тогтмол
Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд: - Байгууллагын сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтанд хамруулах урт, богино хугацааны төлөвлөгөө боловсруулан, эрх бүхий албан тушаалтнаар батлуулах хэрэгжилтийг хангах - Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаанд хяналт тавьж ажиллах - Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний сургалтын хэрэгцээний судалгаа хийж, санал боловсруулах; - Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний тасралтгүй сургалтыг зохион байгуулж багц цагын биелэлтийг хянах - Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд зориулсан ёс зүйн сургалт зохион байгуулах - Шинэ сувилагчийг ажлын байран дээр дадлагажуулах сургалтыг зохион байгуулах;	- Тогтмол - Тогтмол - Тогтмол - Тогтмол - Тогтмол
Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд: - Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний нийгмийн байдлын талаар тогтмол судалгаатай байх, - Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний нийгмийн халамжийг сайжруулах чиглэлээр санал боловсруулан сувилахуйн албаны даргад танилцуулан, хэрэгжүүлэх ажлыг	- Тогтмол - Тогтмол

зохион байгуулах - Дэмжлэг шаардлагатай сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнд төрийн болон төрийн бус байгууллагын тусламж, хөнгөлөлтийг олгуулахад санаачлагатай ажиллах,	
Ажлын байрны V үндсэн зорилтын хүрээнд: - Байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтанд хамрагдах - Төгсөлтийн дараах сургалтанд суралцаж багц цагаа биелүүлэхийн тулд идэвхи санаачлагатай ажиллах - Онол практикийн хуралд илтгэл тавих, эмнэл зүйн удирдамж, сувилахуйн тусламж, үйлчилгээний стандарт, гарын авлага, аргачлал боловсруулахад оролцох - Байгууллагаас зохион байгуулж буй сургалтанд оролцох - Хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх	- 5 жил тутамд - Жил бүр - Тогтмол - Тогтмол - Тогтмол
Ажлын байрны VI үндсэн зорилтын хүрээнд: - Байгууллагын төлөвлгөөний дагуу сургалт, сурталчилгааны болон олон нийтийн ажилд оролцох	- Тогтмол

В.Тавигдах шаардлага

		Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
1. Ажлын байранд Тавигдах шаардлага	1.1 Эмнэл зүйн ур чадварууд	Боловсрол	- Бакалаврын боловсролын зэрэгтэй	
		Мэргэжил	- Сувилагч - “Сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	- Мэргэжлийн зэрэгтэй байх
		Мэргэшил	- Сувилахуйн төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцсан байх	- Урт, богино хугацааны удирдлагын сургалтанд суралцсан
		Туршлага	- Сувилагчаар 5 ба түүнээс дээш жил ажилласан байх	- Тасаг нэгжүүдэд тойрон ажилласан
	1.2 Эмнэл зүйн бус ур чадвар	Гадаад хэл	- Англи хэлний зохих мэдлэгтэй	- Бусад гадаад хэлний мэдлэгтэй байх
		Компьютерийн мэдлэг	- Оффисын хэрэглээний программ дээр ажиллах - Интернэтийн орчин, дотоод сүлжээнд ажиллах	- Шаардлагатай бусад программууд дээр ажиллах
		Судалгааны арга зүй	- Статистикийн талаар тодорхой мэдлэгтэй байх	

	1.3 Бусад ур чадвар	- Удирдан зохион байгуулах - Манлайлах - Шийдвэр гаргах - Багаар ажиллах - Яриа, харилцаа, хувийн соёлтой байх - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх
	1.4 Тусгай шаардлага	- Төрийн албан хаагчийн болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах - Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх

Г. Хүчин зүйлс

1. Ажлын байрны харилцах субъект	
Байгууллагын дотор талд: - Тасгийн эрхлэгчтэй ажлын байрны нөхцөлийг сайжруулах, ажлын байрны стандартыг хангуулах, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх, эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар; - Эмнэлгийн хүний нөөцийн албатай сувилагч нарын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын асуудлаар; - Ерөнхий сувилагч болон тасгийн ахлах сувилагчтай мэргэжлийн тусламж, үйлчилгээ, ажлын үүрэг, хариуцлага болон сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, сувилагч нарын нийгмийн асуудлын талаар шат дараалан харьцах; - Тасгийн эмч нар, бусад сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнтэй үйлчлүүлэгчийн оношлогоо, эмчилгээ, сувилахуйн асуудлаар харьцана.	Байгууллагын гадна талд: - Үйлчлүүлэгч, түүний асран хамгаалагч, ар гэрийнхэнтэй үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн асуудлаар; - Сувилахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаанд нь оролцох. - Үйлчлүүлэгч, түүний ар гэр, асран хамгаалагч, харгалзан дэмжигч - Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмч нар - Бусад төв эмнэлэг, тусгай мэргэжлийн эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн эмч нар - Тухайн мэргэжлийн чиглэлээрх мэргэжлийн нийгэмлэг, холбоод -
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тасгийн эрхлэгчийн өмнө хариуцна

3. Ажлын байрны нөөц хэрэгсэл	4.1.Санхүүгийн:	- Засгийн газрын тогтоолд зааснаар цалинг тогтоох - Хууль тогтоомжоор олгогдох бусад нэмэгдэл ба нэмэгдэл хөлс, урамшуулал
	4.2.Материалын	- Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж - Ажлын байрны стандартыг хангасан өрөө, тавилга - Компьютер, дагалдах хэрэгслийн хамт - Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл жилд 2-оос доошгүй удаа хангагдах - Дотуур холбоо, дотоод сүлжээ
	4.3.Хүний	- Тасгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад ажилтантай хамтран ажиллах
	4.4.Бусад	- Эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт тухай бүр хамрагдах
4. Ажлын байрны нөхцөл		Хэвийн
5. Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр		Шаардлагатай үед тасаг, амбулаторийн сувилагчаар орлон ажиллах

Д.Баталгаажуулалт

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан		Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
…… (байгуулагын нэр) …… (дарга/захирлын эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) …… (Гарын үсэг) оны ...сарын ...-ны өдөр	…… (байгуулагын нэр) …… (шууд удирдах албан хаагчийн эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) …… (Гарын үсэг) оны ...сарын ...-ны өдөр	…… (байгуулагын нэр) …… (мэргэжилтний эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) …… (Гарын үсэг) оны ...сарын ...-ны өдөр

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 5...
дугаар сарын 18...-ны өдрийн 183...
тоот тушаалын гуравдугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар ...

“А” Нийтлэг үндэслэл

Байгууллагын нэр	Нэгжийн нэр	
Сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, клиник, амаржих газар, сувилал, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн тасаг, нэгж болон сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв	.....	
Ажлын байрны нэр	Ангилал	Зэрэглэл
Ахлах сувилагч	Засгийн газрын тогтоолд зааснаар	
Шууд харъяалагдах ажлын байр/албан тушаал	Шууд харъяалах албан тушаал	
- Тасгийн эрхлэгч/ Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга - Сувилахуйн албаны дарга,	Тасгийн болон төвийн сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, ажилтнууд	
Ажлын байрны зорилго	Тасаг, нэгж, төвийн хэмжээнд сувилахуйн тусламж үйлчилгээг зохион байгуулах	
Ажлын байрны үндсэн зорилт	1. Тасаг, нэгж, төвийн хэмжээнд сувилахуйн тусламж үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, явцын хяналтыг хийх 2. Тасгийн сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах 3. Үйлчлүүлэгчид сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэх 4. Сургалтанд хамрагдан, мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх, 5. Бусад	

Б. Ажлын байрны гол үйл ажиллага

Үйл ажиллагаа:	**Хугацаа**
<u>Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд</u>:	
- Сувилагч нарыг сувилахуйн 5 шатлалыг хэрэгжүүлэхэд туслах, чиглүүлэх, үр дүнг тооцох;	- Тогтмол
- Шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлын хангалтыг зохион байгуулж, хяналт тавих;	- Тогтмол
- Сувилагч нарын ажлын уялдаа холбоог хангаж, ажлын	- Тогтмол

ачааллыг тэнцүүлэн, ажил үүргийн хуваарийг мөрдүүлэн, зохицуулах; - Сувилахуйн тусламж, үйлчилгээтэй холбоотой анхан шатны маягт хөтлөлтөнд хяналт тавьж, зөвлөх; - Сувилахуйн тусламж, үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих.	- Тогтмол
<u>Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд:</u> - Шинэ сувилагчийг ажлын байран дээр дадлагажуулах сургалтын төлөвлөгөө гарган зохион байгуулах, сургалтын үр дүнг тооцох; - Сувилагч, эмнэлгийн тусгай мргэжилтнүүдийг мэргэшүүлэх давтан сургалтанд хамруулах төлөвлөгөө гарган, суралцуулах ажлыг зохион байгуулах, - Тасаг, нэгж, төвийн сувилагч, эмнэлгийн тусгай мргэжилтнүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаанд хяналт тавих, багц цагийн сургалтын хэрэгцээний саналаа сувилахуйн албанд өгөх.	- Тогтмол - Тогтмол - Тогтмол
<u>Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд:</u> - Үйлчлүүлэгчид, тэдний асран хамгаалагч, ар гэрийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх ажлыг удирдах, сувилахуйн тусламж, үйлчилгээний талаар сургалт зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх, - Сувилагч нарыг энэ чиглэлээр ажлын байран дээр нь сургах - Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал, эмчилгээ, оношлогоо, үр дүн, эрсдэл, хүндрэлийн талаар үйлчлүүлэгч, түүний асран хамгаалоагчид энгийн, ойлгомжтой хэллэгээр тайлбарлах, зөвлөгөө өгөх	- Тогтмол - Тогтмол - Тогтмол
<u>Ажлын байрны VI үндсэн зорилтын хүрээнд:</u> - Байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтанд хамрагдах - Төгсөлтийн дараах сургалтанд суралцаж багц цагаа биелүүлэхийн тулд идэвхи санаачлагатай ажиллах - Онол практикийн хуралд илтгэл тавих, эмнэл зүйн удирдамж, сувилахуйн тусламж, үйлчилгээний стандарт, гарын авлага, аргачлал боловсруулахад оролцох - Байгууллагаас зохион байгуулж буй сургалтанд оролцох - Хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх	- 5 жил тутамд - Жил бүр - Тогтмол - Тогтмол - Тогтмол
<u>Ажлын байрны V үндсэн зорилтын хүрээнд:</u> - Байгууллагын төлөвлгөөний дагуу сургалт, сурталчилгааны болон олон нийтийн ажилд оролцох	- Тогтмол

В.Тавигдах шаардлага

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1 Эмнэл зүйн ур чадвар	Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	- Бакалавр боловсрлын зэрэгтэй	
		Мэргэжил	- Сувилагч - "Сувилах" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	- мэргэжлийн аль нэг зэрэгтэй байх
		Мэргэшил	- Төрөлжсөн мэргэшлийн сувилахуйн сургалтанд суралцсан байх	- Удирдлагын сургалтанд суралцсан
		Туршлага	- Эмнэлэгт сувилагчаар 3 ба түүнээс дээш жил ажилласан байх	- Тасаг нэгжүүдэд тойрон ажилласан байх
	1.2 Эмнэл зүйн бус ур чадвар	Гадаад хэлний мэдлэг	- Англи хэлний зохих мэдлэгтэй	- Бусад гадаад хэлний зохих мэдлэгтэй байж болох
		Компьютерийн мэдлэг	- Оффисын хэрэглээний программ дээр ажиллах, - Интернетийн орчин, дотоод сүлжээнд ажиллаж чадах	Ажил үүрэгтэй холбоотой бусад программыг ашиглах
		Судалгааны арга зүй	- Статистикийн арга зүй	
	1.3 Бусад ур чадвар		- Манлайлах - Шийдвэр гаргах - Багаар ажиллах - Яриа, харилцаа, хувийн соёлтой байх - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх	
	1.4.Тусгай шаардлага:		- Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах - Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх	

Г. Хүчин зүйлс

2. Ажлын байрны харилцах субъект	
Байгууллагын дотор талд: - Тасгийн эрхлэгчтэй ажлын байрны нөхцөлийг сайжруулах, ажлын байрны стандартыг хангуулах, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх, эмчилгээ, сувилахуйнтусламж,	Байгууллагын гадна талд: - Үйлчлүүлэгч, түүний асран хамгаалагч, ар гэрийнхэнтэй үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн асуудлаар; - Сувилахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай сайн дурын үндсэн дээр үйл

үйлчилгээний чанарыг сайжруулах талаар; - Тасгийн эмч нар, бусад сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнтэй үйлчлүүлэгчийн оношлогоо, эмчилгээ, сувилахуйнасуудлаар харьцана.		ажиллагаанд нь оролцох. - Тухайн мэргэжлийн чиглэлээрх мэргэжлийн нийгэмлэг, холбоод
3. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага		Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тасгийн эрхлэгчийн өмнө хариуцна
4. Ажлын байрны нөөц хэрэгсэл	4.1.Санхүүгийн	- Засгийн газрын тогтоолд зааснаар цалинг тогтоох - Хууль тогтоомжоор олгогдох бусад нэмэгдэл ба нэмэгдэл хөлс, урамшуулал
	4.2.Материалын	- Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж - Ажлын байрны стандартыг хангасан өрөө, тавилга - Компьютер, дагалдах хэрэгслийн хамт - Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл - Дотуур холбоо, дотоод сүлжээ
	4.3.Хүний	- Тасгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад ажилтантай хамтран ажиллах
	4.4.Бусад	- Эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт тухай бүр хамрагдах
5. Ажлын байрны нөхцөл		Хэвийн
6. Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр		Шаардлагатай үед тасаг, амбулаторийн сувилагчийг орлон ажиллах

Д.Баталгаажуулалт

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан		Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
..... (байгуулагын нэр) ..... (дарга/захирлын эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) ..... (Гарын үсэг) оны ...сарын ...-ны өдөр	..... (байгуулагын нэр) ..... (шууд удирдах албан хаагчийн эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) ..... (Гарын үсэг) оны ...сарын ...-ны өдөр	..... (байгуулагын нэр) ..... (мэргэжилтний эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) ..... (Гарын үсэг) оны ...сарын ...-ны өдөр

Эрүүл мэндийн сайдын 2012 оны ...
дугаар сарын ...-ны өдрийн ... тоот
тушаалын дөрөвдүгээр хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар .....

”А“Нийтлэг үндэслэл

Байгууллагын нэр	Нэгжийн нэр	
Өрх, тосгоны эрүүл мэндийн төв		
Ажлын байрны нэр	Ангилал	Зэрэглэл
Сувилагч	Засгийн газрын тогтоолд зааснаар	
Шууд харьяалагдах ажлын байр (албан тушаал)	Шууд харьяалах ажлын байр (албан тушаал)	
Өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга	Сувилагч, бусад ажилтан	
Ажлын байрны зорилго	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг батлагдсан стандарт, сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдамжийн дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх	
Ажлын байрны үндсэн зорилт	1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх 2. Сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэх 3. Яаралтай тусламж үзүүлэх 4. Сургалтанд хамрагдах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, оролцох 5. Бусад	

“Б” Ажлын байрны гол үйл ажиллагаа

Үйл ажиллагаа:	Хугацаа
Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд: - Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад оролцох - Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох, харьяалах байгууллагын хүрээнд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, - Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиг үүргийн дагуу оролцох, мэдээлэх - Эрүүл мэндийн сайн дурын ажилтнаар дамжуулан харьяалах хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн боловрол олгох, - урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад чиг үүргийн дагуу оролцох - Нийгмийн эрүүл мэндийн бусад үйл ажиллагаанд оролцох	- Тогтмол - Тогтмол - Тогтмол - Тогтмол - Тогтмол

Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд: - Үйлчлүүлэгчийг хүлээн авах, асуумж авах, үзлэг хийх, үйлчлүүлэгчийн эмнэлгийн карт, эрүүл мэндийн дэвтэр, холбогдох маягт, баримт бичгүүдийг стандартын дагуу хөтлөх - Зонхилон тохиолдох өвчний оношлогоо, эмчилгээний стандарт, сувилахуйн түгээмэл үйлдлийн стандарт, сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдамжийн дагуу үйлчилгээ үзүүлэх - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгээс шалтгаалсан халдварын дэглэм, зааврыг мөрдөх - Үйлчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний үр дүнг хянах, шаардлагатай шинжилгээг хийх, - Туслах сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд эмчилгээ, сувилгааны чиглэлээр зааварчилгаа өгөх, хяналт тавих - Үйлчлүүлэгч, түүний ар гэрт энгийн, ойлгомжтой хэллэгээр тайлбарлах, зөвлөгөө өгөх - Нөхөн сэргээх, хөнгөвчлөх эмчилгээг стандартын дагуу хийх	- Тогтмол - Тогтмол - Тогтмол - Тогтмол - Тогтмол - Тухай бүр - Тогтмол
Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд: - Амь тэнссэн болон яаралтай тохиолдолд сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэх - Олон улсын хөл хориот өвчний голомт, гамшгийн үед дайчлагдан ажиллах	- Тухай бүр - Тухай бүр
Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд: - Байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтанд хамрагдах - Төгсөлтийн дараах сургалтын багц цагийн хөтөлбөрт хамрагдах - Онол практикийн хуралд илтгэл тавих, оношлогоо, эмчилгээний гарын авлага, аргачлал боловсруулахад оролцох	- 3-5 жил тутамд - Жил бүр - Тухай бүр
Ажлын байрны V үндсэн зорилтын хүрээнд: - Байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох - Хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх	- Тогтмол - Тогтмол

“B” Тавигдах шаардлага

		Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1Эмнэл зүйн ур чадвар	Боловсрол	- Дипломын болон бакалаврын боловсролын зэрэгтэй	
		Мэргэжил	- Сувилагч - “Сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	- Мэргэжлийн зэрэгтэй байж болно
		Мэргэшил	- Ерөнхий сувилахуйн мэргэшилтэй	
		Туршлага	- Ажилласан жил харгалзахгүй	

1.2 Эмнэл зүйн бус ур чадвар	Гадаад хэл	- Англи хэлний зохих мэдлэгтэй	- Бусад гадаад хэлний мэдлэгтэй
	Компьютерийн мэдлэг	- Хэрэглээний программ ашиглах - Интернэтийн орчин, дотоод сүлжээнд ажиллах	-
	Судалгааны арга зүй	- Статистик шинжилгээ хийх	-
1.3 Бусад ур чадвар		- Багаар ажиллах - Яриа, харилцаа, хувийн соёлтой байх - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх - Манлайлах - Шийдвэр гаргах	
1.4.Тусгай шаардлага:		- Төрийн албан хаагчийн болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах - Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх	

“Г” Хүчин зүйлс:

2 Ажлын байрны харилцах субъект		
Байгууллагын дотор талд: - Өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга - Бусад их эмч, сувилагч, бусад ажилтан		Байгууллагын гадна талд: - Үйлчлүүлэгч, түүний ар гэр, асран хамгаалагч, харгалзан дэмжигч - Мэргэжлийн чиглэлээрх мэргэжлийн нийгэмлэг, холбоо - Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар - Эрүүл мэндийн сайн дурын ажилтан - Төрийн болон төрийн бус бусад байгууллага
3 Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага		Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн даргын өмнө хариуцна.
4 Ажлын байрны нөөц хэрэгсэл	4.1.Санхүүгийн	- Үндсэн цалинг Засгийн газрын тогтоолын дагуу тооцож олгох - Хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшил олгох
	4.2.Материалын	- Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж - Ажлын байрны стандартыг хангасан өрөө, тавилга - Компьютер, дагалдах хэрэгслийн хамт - Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл

	4.3.Хүний	- Эмч, сувилагч, бусад ажилтантай хамтран ажиллах
	4.4.Бусад	- Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жил бүр үнэ төлбөргүй хамрагдах
5 Ажлын байрны нөхцөл		Хэвийн
6 Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр		Шаардлагатай үед дарга, бусад сувилагчийг орлон ба хавсарч ажиллах

“Д” Баталгаажуулалт

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан	Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
Өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга ..... /Эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ ..... /Гарын үсэг/ ...оны ...сарын ...-ны өдөр	Сувилагч ..... /Эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ ..... /Гарын үсэг/ ...оны ...сарын ...-ны өдөр

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
...5... дугаар сарын ...18...-ны өдрийн 183
тоот тушаалын тавдугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар .....

”А“Нийтлэг үндэслэл

Байгууллагын нэр	Нэгжийн нэр	
Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг		
Ажлын байрны нэр	Ангилал	Зэрэглэл
Сувилагч	Засгийн газрын тогтоолд зааснаар	
Шууд харьяалагдах ажлын байр (албан тушаал)	Шууд харьяалах ажлын байр (албан тушаал)	
Сумын эрүүл мэндийн төвийн дарга, сум дундын эмнэлгийн эрхлэгч	Сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, бусад ажилтан	
Ажлын байрны зорилго	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг батлагдсан стандарт, сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдамжийн дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх	
Ажлын байрны үндсэн зорилт	1. Сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэх 2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх 3. Яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлэх 4. Сургалтанд хамрагдах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, оролцох 5. Бусад	

“Б” Ажлын байрны гол үйл ажиллагаа

Үйл ажиллагаа:	Хугацаа
<u>Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд:</u> - Үйлчлүүлэгчийг хүлээн авах, асуумж авах, үзлэг хийх, өвчний түүх, үйлчлүүлэгчийн эмнэлгийн карт, эрүүл мэндийн дэвтэр, холбогдох маягт, баримт бичгүүдийг стандартын дагуу хөтлөх	- Тогтмол
- Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандарт, сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдамжийн дагуу сувилахуйн тусламж үзүүлэх	- Тогтмол
- Үйлчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний үр дүнг хянах, шаардлагатай шинжилгээг хийх, явцын дүгнэлт бичих	- Тогтмол
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгээс шалтгаалсан халдварын дэглэм, зааврыг мөрдөх	- Тогтмол
- Туслах сувилагч, бусад сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд сувилахуйн үйл ажиллагааны	

зааварчилгаа өгөх, хяналт тавих - Үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд түүний эрүүл мэндийн байдал, эмчилгээ, оношлогоо, үр дүн, эрсдэл, хүндрэлийн талаар энгийн, ойлгомжтой хэллэгээр тайлбарлах, зөвлөгөө өгөх - Нөхөн сэргээх, хөнгөвчлөх эмчилгээг стандартын дагуу хийх - Эмнэлгийн анхан шатны маягт хөтлөх	- Тухай бүр - Тогтмол - Тогтмол
<u>Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд:</u> - Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, урьдчилан сэргийлэх үзлэгт чиг үүргийн дагуу оролцох - Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох, үйл ажиллаганд шууд болог эрүүл мэндийн сайн дурын ажилтнаар дамжуулан оролцох - Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиг үүргийн дагуу оролцох, - Нийгмийн эрүүл мэндийн бусад үйл ажиллагаанд оролцох	- Тогтмол - Тогтмол - Тухай бүр - Тогтмол
<u>Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд:</u> - Үйлчлэх хүрээний хүн амын яаралтай тусламжийн дуудлаганд эмчийн хамт явах - Амь тэнссэн болон яаралтай тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх - Олон улсын хөл хориот өвчний голомт, гамшгийн үед дайчлагдан ажиллах	- Тухай бүр - Тухай бүр - Тухай бүр
<u>Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд:</u> - Байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтанд хамрагдах - Төгсөлтийн дараах сургалтын багц цагийн хөтөлбөрт хамрагдах - Онол практикийн хуралд илтгэл тавих, оношлогоо, эмчилгээний гарын авлага, аргачлал боловсруулахад оролцох	- 3-5 тутамд - Жил бүр - Тухай бүр
<u>Ажлын байрны V үндсэн зорилтын хүрээнд:</u> - Байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох - Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэхэд оролцох - Хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх	- Тогтмол - Тогтмол - Тухай бүр

“В” Тавигдах шаардлага

1.Ажлын байранд Тавигдах шаардлага	1.1 Эмнэл зүйн ур чадвар	Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	- Дипломын болон бакалаврын боловсролын зэрэгтэй	- Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
		Мэргэжил	- Сувилагч - “Сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	- Мэргэжлийн зэрэгтэй байж болно
		Мэргэшил	- Төрөлжсөн мэргэшлийн сургалтанд хамрагдсан буюу мэргэжлийн үнэмлэхтэй байх	-
		Туршлага	- Ажилласан жил харгалзахгүй	-
	1.2 Эмнэл зүйн бус ур чадвар	Гадаад хэл	- Англи хэлний зохих мэдлэгтэй	- Бусад гадаад хэлний зохих мэдлгтэй байж болно
		Компьютерийн мэдлэг	- Хэрэглээний программ ашиглах - Интернэтийн орчин, дотоод сүлжээнд ажиллах	
		Судалгааны арга зүй	- Статистик шинжилгээ хийх	
	1.3 Бусад ур чадвар		- Багаар ажиллах - Яриа, харилцаа, хувийн соёлтой байх - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх	
	1.4.Тусгай шаардлага:		- Төрийн албан хаагчийн болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах - Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх	

“Г” Хүчин зүйлс:

2 Ажлын байрны харилцах субъект	
Байгууллагын дотор талд:	Байгууллагын гадна талд:
- Сумын эрүүл мэндийн төвийн дарга, сум дундын эмнэлгийн эрхлэгч - Бусад их эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад ажилтнууд	- Үйлчлүүлэгч, түүний ар гэр, асран хамгаалагч, харгалзан дэмжигч - Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч нар - Тухайн мэргэжлийн чиглэлээрх мэргэжлийн нийгэмлэг, холбоод - Эрүүл мэндийн сайн дурын ажилтан - Төрийн болон төрийн бус бусад

		байгууллага
3 Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага		Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг сумын эрүүл мэндийн төвийн дарга, сум дундын эмнэлгийн эрхлэгчийн өмнө хариуцна.
4 Ажлын байрны нөөц хэрэгсэл	4 .1.Санхүүгийн:	- Үндсэн цалинг Засгийн газрын тогтоолын дагуу тооцож олгох - Хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшил олгох
	4. 2.Материалын	- Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж - Ажлын байрны стандартыг хангасан өрөө, тавилга - Компьютер, дагалдах хэрэгслийн хамт - Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл
	4.3.Хүний	- Эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад ажилтантай хамтран ажиллах
	4 .4.Бусад	- Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жил бүр үнэ төлбөргүй хамрагдах
5 Ажлын байрны нөхцөл		Ердийн
6 Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр		Шаардлагатай үед бусад сувилагчийг орлон ба хавсарч ажиллах

“Д” Баталгаажуулалт

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан	Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
Сумын эрүүл мэндийн төвийн дарга, сум дундын эмнэлгийн эрхлэгч ..... /Эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ ..... /Гарын үсэг/ ...оны ...сарын ...-ны өдөр	Сувилагч ..... /Эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ ..... /Гарын үсэг/ ...оны ...сарын ...-ны өдөр

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 5....
дугаар сарын 18..-ны өдрийн 183 тоот
тушаалын зургаадугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар .....

”А“Нийтлэг үндэслэл

Байгууллагын нэр	Нэгжийн нэр	
Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	Дотрын тасаг	
Ажлын байрны нэр	Ангилал	Зэрэглэл
Сувилагч	Засгийн газрын тогтоолд зааснаар	
Шууд харьяалагдах ажлын байр (албан тушаал)	Шууд харьяалах ажлын байр (албан тушаал)	
Сувилахуйн албаны дарга Тасгийн эрхлэгч	Сувилагч, туслах сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, бусад ажилтан	
Ажлын байрны зорилго	Байгууллагын тасаг, нэгжийн чиг үүргийн хүрээнд сувилахуйн тусламж, үйлчилгээг батлагдсан стандарт, сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдамжийн дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх	
Ажлын байрны үндсэн зорилт	1. Сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэх 2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх 3. Яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлэх 4. Сургалтанд хамрагдах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, оролцох 5. Бусад	

“Б” Ажлын байрны гол үйл ажиллагаа

Ажлын байрны гол үйл ажиллагаа:	Хугацаа
Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд:	
- Үйлчлүүлэгчийг тасагт хүлээн авах, асуумж авах, үзлэг хийх, өвчний түүх, холбогдох маягт, баримт бичгүүдийг стандартын дагуу хөтлөх	- Тогтмол
- Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандарт, сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдамжийн дагуу тусламж, үзүүлэх	- Тогтмол
- Үйлчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний үр дүнг хянах, эмчлэгч эмчид мэдээлэх	- Тогтмол
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгээс шалтгаалсан халдварын дэглэм, зааврыг мөрдөх	- Тогтмол
- Туслах сувилагч болон бусад сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд эмчилгээ, сувилгааны чиглэлээр зааварчилгаа өгөх, хяналт тавих	- Тогтмол
- Үйлчлүүлэгч, түүний асран хамгаалагчид түүний эрүүл мэндийн байдал, эмчилгээ, оношлогоо, үр дүн, эрсдэл,	- Тогтмол

хүндрэлийн талаар энгийн, ойлгомжтой хэллэгээр тайлбарлах, зөвлөгөө өгөх	
Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд: - Үйлчлүүлэгчид эрүүл аж төрөх ёс, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр зөвлөгөө өгөх - Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр тасаг, нэгжийн хүрээнд сургалт зохион байгуулах, оролцох - Нийгмийн эрүүл мэндийн бусад үйл ажиллагаанд оролцох	- Тогтмол - Тогтмол - Тогтмол
Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд: - Шаардлагатай тохиолдолд яаралтай тусламжийн дуудлаганд эмчтэй хамт явах - Амь тэнссэн болон яаралтай тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх - Олон улсын хөл хориот өвчний голомт, гамшгийн үед дайчлагдан ажиллах	- Тухай бүр - Тухай бүр - Тухай бүр
Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд: - Байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтанд хамрагдах - Төгсөлтийн дараах сургалтын багц цагийн хөтөлбөрт хамрагдах - Онол практикийн хуралд илтгэл тавих, оношлогоо, эмчилгээний гарын авлага, аргачлал, мэргэжлийн ном туурвихад оролцох	- 3-5 жил тутамд - Жил бүр - Тухай бүр
Ажлын байрны V үндсэн зорилтын хүрээнд: - Байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох - Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэхэд оролцох - Хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх	- Тогтмол - Тогтмол - Тогтмол

“В” Тавигдах шаардлага

		Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1 Эмнэл зүйн ур чадвар	Боловсрол	Дипломын болон бакалаврын боловсролын зэрэгтэй	
		Мэргэжил	- Сувилагч - “Сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	- Мэргэжлийн зэрэгтэй байх
		Мэргэшил	- Үндсэн мэргэшлийн сургалтанд хамрагдсан буюу мэргэжлийн дипломтой байх	- Төрөлжсөн мэргэшлийн сургалтанд хамрагдсан - Сувилахуйн магистр, докторын

			зэрэгтэй байж болно
	Туршлага	- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт 1-ээс доошгүй жил ажилласан	-
1.2 Эмнэл зүйн бус ур чадвар	Гадаад хэл	- Англи хэлний анхан дунд түвшнээс доошгүй мэдлэгтэй	- бусад хэлний анхан дунд түвшнээс доошгүй мэдлэгтэй
	Компьютерийн мэдлэг	- Хэрэглээний программ бүрэн ашиглах - Интернэтийн орчин, дотоод сүлжээнд чөлөөтэй ажиллах	
	Судалгааны арга зүй	- Статистик шинжилгээ хийх	
1.3 Бусад ур чадвар		- Багаар ажиллах - Яриа, харилцаа, хувийн соёлтой байх - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх	
1.4.Тусгай шаардлага:		- Төрийн албан хаагчийн болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах - Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх	

“Г” Хүчин зүйлс:

2. Ажлын байрны харилцах субъект	
Байгууллагын дотор талд: - Тасгийн эрхлэгчтэй ажлын байрны нөхцөлийг сайжруулах, ажлын байрны стандартыг хангуулах, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх, эмчилгээ, сувилгааны тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар; - Сувилахуйн албаны дарга, нэгжийн ахлах сувилагчтай мэргэжлийн тусламж, үйлчилгээ, ажлын үүрэг, хариуцлага болон сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, сувилагч нарын нийгмийн асуудлаар; - Кабинет, эмч нар, бусад сувилагч,	Байгууллагын гадна талд: - Үйлчлүүлэгч, түүний асран хамгаалагч, ар гэрийнхэнтэй үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн асуудлаар; - Сувилахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаанд нь оролцох.

эмнэлгийн мэргэжилтэнтэй үйлчлүүлэгчийн оношлогоо, эмчилгээ, сувилгааны асуудлаар харьцана.		
3. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тасгийн эрхлэгч, аймаг, дүүргийн нэгдсэн даргын өмнө хариуцна.	
4. Ажлын байрны нөөц хэрэгсэл	4.1.Санхүүгийн:	- Үндсэн цалинг Засгийн газрын тогтоолын дагуу тооцож олгох - Хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшил олгох
	4.2.Материалын	- Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж - Ажлын байрны стандартыг хангасан өрөө, тавилга - Компьютер, дагалдах хэрэгслийн хамт - Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл - Дотуур холбоо, дотоод сүлжээ
	4.3.Хүний	- Тасгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад ажилтантай хамтран ажиллах
	4.4.Бусад	- Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жил бүр үнэ төлбөргүй хамрагдах
5. Ажлын байрны нөхцөл		Ердийн
6. Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр		Шаардлагатай үед тасаг, амбулаторийн мэргэжлийн эмчээр орлон ба хавсран ажиллах

“Д” Баталгаажуулалт

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан		Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга ..... /Эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ ..... /Гарын үсэг/ оны ...сарын ...-ны өдөр	..... /тасгийн нэр/ Эрхлэгч ..... /Эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ ..... /Гарын үсэг/ оны ...сарын ...-ны өдөр	..... /тасгийн нэр/ Сувилагч ..... /Эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ ..... /Гарын үсэг/ оны ...сарын ...-ны өдөр

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 5 ....
дугаар сарын 18..-ны өдрийн 183 тоот
тушаалын долоодугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар .....

“А” Нийтлэг үндэслэл

Байгууллагын нэр	**Нэгжийн нэр**	
Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг,	**Амбулаторын дотрын кабинет**	
Ажлын байрны нэр	Ангилал	Зэрэглэл
Сувилагч	Засгийн газрын тогтоолд зааснаар	
Шууд харъяалагдах ажлын байр (албан тушаал)	Шууд харъяалах албан тушаал	
- Амбулаторын эрхлэгч - Сувилахуй албаны дарга - Ахлах сувилагч	Тасаг, нэгжийн туслах сувилагч, үйлчлэгч бусад ажилчид	
Ажлын байрны зорилго	Тасаг нэгжийн чиг үүргийн хүрээнд сувилахуйн тусламж , үйлчилгээг батлагдсан стандарт сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдамжийн дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх	
Ажлын байрны үндсэн зорилт	1. Амбулаторт үйлчлүүлэгчдийн бүртгэл хөтлөх 2. Амбулаторын эмчийн үйл ажиллагаанд туслах, хамтран ажиллах, 3. Амбулаторийн тусламж, үйлчилгээнд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжийн болон өрөө тасалгааны бэлэн байдлыг хангах, 4. Сургалтанд оролцох, мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх 5. Бусад	

Б. Ажлын байрны гол үйл ажиллагаа

